



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 02-А/143

Дархан

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл батлах тухай” Засгийн газрын 2019 оны 275, 2021 оны 377 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах журам”-ын 2, 3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны “Зөвшөөрөл олгох тухай” 341 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Бүтэц орон тоог батлах тухай” 2021 оны 01-А/28 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн даргын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг зургаадугаар, Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг долоодугаар, аймгийн Ерөнхий эдийн засагч, ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг наймдугаар, Өрсөлдөөний зохицуулалт хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зах зээлийн судалгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг есдүгээр, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг аравдугаар, төсвийн зарлага хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван нэгдүгээр, дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван хоёрдугаар, бүртгэлийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван гуравдугаар, хүний нөөцийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван дөрөвдүгээр, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван тавдугаар, гадаад харилцааны мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван зургаадугаар, хурал, зөвлөгөөн хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван долоодугаар, хууль тогтоомжийн системчлэл, бүртгэл, лавлагааны мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван наймдугаар, Үндэсний аюулгүй байдал, терроризмтой тэмцэх, ХАСХОМ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван есдүгээр, хөрөнгө оруулалтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорьдугаар, байгаль орчин, газрын харилцаа, хүнд үйлдвэрийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин нэгдүгээр, дэд бүтцийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин хоёрдугаар, хот байгуулалт, архитектур төлөвлөлтийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин гуравдугаар, хөдөө аж ахуй, ахуй үйлчилгээний салбарын бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин

дөрөвдүгээр, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалын бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин тавдугаар, төсвийн байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин зургаадугаар, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин долоодугаар, эрүүл мэндийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин наймдугаар, хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хорин есдүгээр, соёл, спортын бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг гучдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтыг төрийн захиргааны албан хаагчдад танилцуулж, төрийн албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Баярсайхан)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2019 оны 2-А/120 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

